



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 81/81

Ховд

Ц.Батзоригт цалинтай чөлөө
олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны A/131 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нутгийн удирдлагын ордны үйлчилгээний тасгийн Сантехникийн слесарь Ц.Батзориг нь үндэсний их баяр наадмын Үндэсний сурын харвааны бэлтгэлд оролцохоор чөлөө хүссэн тул 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын 5 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. Ц.Батзоригийг чөлөөтэй байх хугацааны цалинг бодож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯРСҮХ



8400003 0397
Tush B/81 Ba